

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

Г Зарим банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооноос тогтоосон банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг хангаж ажиллаагүй дор нэр дурьдсан компаниудын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй:

- 1/ “Гэрэл инвест ББСБ” ХХК;
- 2/ “Зул оюу ББСБ” ХХК;
- 3/ “Монголиа Гонконг финанс корпораци ББСБ” ХХК;
- 4/ “Өнө ингүүмэл ББСБ” ХХК;
- 5/ “Өрнө дорнын гүүр ББСБ” ХХК;
- 6/ “Смолл энд медиум бизнес кредит ББСБ” ХХК;
- 7/ “Сэдхаан ББСБ” ХХК;
- 8/ “Хөгжил эх ББСБ” ХХК;
- 9/ “Хөгжлийн түлхүүр ББСБ” ХХК;
- 10/ “ЭБХА ББСБ” ХХК;
- 11/ “Ялгуулагч ББСБ” ХХК

2. Хорооноос тогтоосон банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг хангаж ажиллаагүй “Футур эволюшн ББСБ” ХХК-ийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт

хийх, “Их жас ББСБ” ХХК-ийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН